

**ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХИЙСЭН ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 01 дүгээр  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Оюунгэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо төслийн анхны хэлэлцүүлгийг 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хийлээ.

Хуулийн төслийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй саналын томъёолол нэг бүрээр санал хураалгасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун төслийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалтыг хасах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг хасах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл төслийн 24 дүгээр зүйлд "Тариалангийн талбайг мал, амьтны хөлөөс хамгаалах зорилгоор мал төлбөртэй хаших үйл ажиллагааг явуулах зөвшөөрлийг сумын Засаг дарга, иргэн, хуулийн этгээдэд өгч болно" гэсэн хэсэг нэмэх гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Ц.Оюунгэрэл нар гаргасан саналаараа цөөнх болов.


Тариалангийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тариалангийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ЭРДЭНЭЧИМЭГ**

**ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн  
байнгын хорооны дэмжсэн санал:**

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.”хөрс” гэж Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.1-д заасныг;”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “нөөцөд” гэснийг “ашиглагдаагүй” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “биологи, физик-химийн” гэснийг “физик-механик шинж, хими, биологийн” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.6.”тариалангийн бүс нутаг” гэж таримал ургамал ургуулах хөрс, цаг уурын тохиромжтой нөхцөл бүрдсэн нутагт газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн зохистой уялдааг хангах зорилгоор төрөөс тусгайлан тогтоосон бүс нутгийг.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

5.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт доор дурдсан 3.1.7 дахь заалт нэмэх:

“3.1.7.”эрчимжсэн мал аж ахуй” гэж суурин болон хагас суурин байдлаар өндөр ашиг шимт мал, тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх үйл ажиллагааг.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

6.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талаарх Засаг даргын саналыг хэлэлцэж шийдвэр гаргана.

5.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг үндэслэн гаргасан сум, дүүргийн Засаг даргын саналыг нэгтгэж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулсны үндсэн дээр тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талаарх тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

5.4.Энэ хуулийн 5.1, 5.2 дахь хэсэг улсын тусгай хэрэгцээний газарт хамаарахгүй.

5.5.Энэ хуулийн 5.3-д заасан байгууллагын зөвшөөрөлгүйгээр атар газрыг тариалангийн зориулалтаар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

7.Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий хэсэг нэмэх:

6...Тариалангийн газарт тариалангийн зориулалтаар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа, элдэншүүлэгт оруулсан нийт талбайг хамааруулна.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.Уриншилсан газарт хөрсөнд чийг хуримтлуулах, хог ургамлаас цэвэрлэх зорилгоор механик болон химийн аргаар боловсруулж өнжөөсөн тариалангийн талбай хамаарна.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

9.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "хоёр" гэсний дараах "хүртэл" гэснийг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

10.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн "хоёроос дээш" гэснийг "гурван" гэж өөрчлөх

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

11.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**"13 дугаар зүйл.Тариалангийн үйлдвэрлэлтэй холбоотой бусад газар**

13.1.Тариалангийн үйлдвэрлэлтэй холбоотой бусад газарт дараах газар хамаарна:

13.1.1.хөдөө аж ахуйн туршилт, судалгааны талбай;

13.1.2.тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн газар."

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"14.2.1.тариалангийн газрын хөрсний үржил шим алдагдсан, элэгдэлд орсон, давсжсан, намагшсны улмаас тариалангийн үйлдвэрлэлд тохиромжгүй болсон нь энэ хуулийн 26.2-т заасан шинжилгээгээр тогтоогдсон;"

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

13.Зарчмын зөрүүтэй 6 дахь саналтай нийцүүлэн төслийн 14 дүгээр зүйлийн тариалангийн газрын зориулалт өөрчлөхтэй холбогдсон 14.3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулах:

"14...Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 14.2.1-д заасан шинжилгээний дүнд үндэслэсэн тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх талаарх Засаг даргын саналыг хэлэлцэж шийдвэр гаргана.

14...Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн гаргасан сум, дүүргийн Засаг даргын саналыг нэгтгэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулсны үндсэн дээр тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

14.Төслийн 14 дүгээр зүйлийн доор дурдсан 14.6 дахь хэсгийг хасах:

“14.6.Тариалангийн газарт дараах зориулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулж болно:

14.6.1.эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр;

14.6.2.эрчимжсэн мал аж ахуйн барилга байгууламж, дэд бүтэц;

14.6.3.газар тариалан болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой бусад барилга байгууламж;

14.6.4.хөдөө аж ахуйн туршилт, судалгаа.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

15.Төслийн 15 дугаар зүйлийн “хураан авах ургацын хэмжээ таримлын төрлөөр;” гэсэн 15.2.3 дахь заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

16.Төслийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.6.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тариалангийн газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх тохиолдолд тариалангийн газар эзэмших, эрхийг Газрын тухай хуулийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

17.Төслийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “Газрыг” гэснийг “Энэ хуулийн 15.7-д заасан газрыг” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

18.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтын “үр тарианы” гэсний өмнө “зусах болон өвөлжих” гэж, 16.2.4 дэх заалтын “тэжээлийн ургамал” гэсний өмнө “нэг ба олон наст” гэж тус тус нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

19.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.8 дахь заалтыг “бусад таримал.” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

20.Төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “хашсан” гэснийг “тусгайлсан” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

21.Төслийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “нөөц хэмнэсэн, хүн ажиллахад таатай” гэснийг “эдийн засгийн үр ашигтай, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг хангасан,” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

22.Төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.4.Атар болон атаршсан газрыг эхний удаа эргэлтэд оруулах, холбогдох технологийн дагуу усалгаатай талбайг боловсруулах болон ногоон бордуурт уринш хийхээс бусад тохиолдолд үр тарианы үйлдвэрлэлд газрын хөрсийг хөмрүүлж хагалах техник, технологи ашиглахыг хориглоно.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

23.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “дэмжлэг” гэсний өмнө “мөнгөн болон мөнгөн бус” гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

24. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.2.Энэ хуулийн 19.1-д заасан дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

25.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5.1 дэх заалтын "шинээр байгуулах," гэсний дараа "өргөтгөх," гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

26.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5.2 дахь заалтын "бүрдүүлэх" гэснийг "төлөвшүүлэх" гэж өөрчлөх, мөн заалтын "ойн зурвас байгуулах," гэсний дараах "хаших" гэснийг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

27.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5.3, 19.5.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"19.5.3.үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний сорт бүтээх, сорих, сортын үр, суулгац үржүүлж, үйлдвэрлэх болон төмсний бичил булцуу үйлдвэрлэх;

19.5.4.үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэл хийх, засвар болон техникийн үйлчилгээний төв байгуулах;"

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

28.Төслийн 19 дүгээр зүйлийн "төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний талбайг усалгаажуулах." гэсэн 19.5.6 дахь заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

29.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэгт доор дурдсан заалт нэмэх:

"19.5..үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах;"

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

30.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан хэсгүүд нэмэх:

"19...Тариалангийн үйлдвэрлэлийг даатгалд хамруулах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

19...Дотоодын хэрэгцээнээс илүү гарсан тариалангийн бүтээгдэхүүнийг экспортлож болно.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

31.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн дараа “Энэ хуулийн 14.2.1-д заасан газрыг тариалангийн эргэлтэд оруулах зорилгоор хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээ авсан бол төрөөс дэмжлэг үзүүлж болно” гэсэн хэсэг нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

32.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын “барьцаалах,” гэсний дараа “шилжүүлэх” гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

33.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтын “гурваас таван” гэснийг “таваас доошгүй” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

34.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.6.таримлын төрөл тус бүрээр, тариалсан болон хураасан ургац, бэлтгэсэн уринш, талбайн ашиглалтын талаарх мэдээг сум, дүүргийн Засаг даргад тухай бүр гаргаж өгөх;”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

35.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалтын “орон нутгийн” гэснийг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

36.Төслийн 20 дугаар зүйлийн “улсын дундаж үр тарианы ургац авсан байх” гэсэн 20.2.12 дахь заалтыг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 20.2...заалт нэмэх:

“20.2...эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу тариалангийн технологийг мөрдөх;”



**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

37.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тариалан эрхлэгчдийн саналд тулгуурлан боловсруулж, сум, дүүрэг тус бүрээр баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

38.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Үр тарианы” гэснийг “Тариалангийн бүтээгдэхүүний” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

39.Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийн “хүлэмжийн” гэснийг “жимс, жимсгэний” гэж, 22.1 дэх хэсгийн “хүлэмжийн аж ахуйд ургуулсан ногоогоор” гэснийг “жимс, жимсгэнээр” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

40.Төслийн 22 дугаар зүйлийн “Хөтөлбөрт тариалах төмс, хүнсний ногоог нэр төрлөөр, хураах ургацын хэмжээ, аж ахуйн нэгж, иргэний үүрэг, шинээр барих өвлийн хүлэмжийн багтаамж, тоо хэмжээ, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тусгах бөгөөд хөтөлбөрийг Засгийн газар баталж, жил бүр дүгнэж тайланг Засгийн газарт танилцуулна.” гэсэн 22.2 дахь заалтыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

41. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “мянган” гэснийг “таван зуун” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

42.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.3.Энэ хуулийн 24.2-т заасан бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчийг тухайн орон нутагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах тээврийн зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 1 удаа хариуцна.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

43.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

24.5.Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн болон хууль зүй, сангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

44.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтын "нутагшсан" гэсний дараа " ирээдүйтэй" гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

45.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын "ургамал" гэсний өмнө "эрдэс, органик бордоо," гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

46. Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"27.2.Агрохими, агрофизикийн шинжилгээний дүнгээр хөрсний төлөв байдал, чанарыг өмнөх шинжилгээний дүнгээс дордуулсан нь мэргэжлийн байгууллагын шинжилгээ, дүгнэлтээр тогтоогдсоны дагуу сайжруулах тодорхой арга хэмжээ авах талаар тариалангийн газар эзэмшигч, ашиглагчид хугацаатай мэдэгдэл өгч, зөвлөмж хүргүүлнэ."

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

47.Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт доор дурдсан заалт нэмэх:

"28.1...энэ хуулийн 20.2.2-т заасныг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгох;"

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

### Найруулгын шинжтэй санал:

1. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "тариалангийн" гэснийг "тариалсан" гэж өөрчлөх.
2. Төслийн 14 дүгээр зүйлийн гарчгийн "Тариалангийн газарт хөдөө аж ахуйн бусад үйл ажиллагаа эрхлэх" гэснийг хасах.
3. 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "Энэ хуулийн 14.6-д зааснаас бусад тохиолдолд" гэснийг хасах.
4. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн "дүгнэлтийг" гэснийг "шийдвэрийг" гэж өөрчлөх.
5. Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн "хамгийн багадаа дөчин жил" гэснийг "дөчин жилээс доошгүй байна." гэж өөрчлөх.
6. Төслийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн "сэргээх," гэснийг "сэргээж", "барагдуулах үүрэгтэй" гэснийг "барагдуулна" гэж өөрчлөх.
7. Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.7 дахь заалтын "гоо сайхны" гэснийг "гоёл чимэглэлийн" гэж өөрчлөх.
8. Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 25.1.1 дэх заалтын "тэг" гэсний дараа "элдэншүүлгийн" гэж нэмэх.
9. Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн "мэргэжил бүхий" гэснийг "мэргэжлийн" гэж өөрчлөх.
10. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5.5 дахь заалтын "барих" гэснийг "байгуулах" гэж өөрчлөх.
11. Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.11-н "хөтөлж хэвшсэн байх" гэснийг "хөтлөх" гэж өөрчлөх.
12. 9 дэх зарчмын зөрүүтэй саналтай нийцүүлэн төслийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтын "2" гэсний дараах "хүртэл" гэснийг хасах.
13. Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн "ногооны" гэснийг "ногоо, жимс, жимсгэний" гэж өөрчлөх.
14. Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "40.7" гэснийг "40.6" гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

**Хоёр. Байнгын хорооны дэмжээгүй санал:**

**1.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:**

5...Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу усалгаатай тариалан эрхлэх зориулалтаар уст цэгийн орчимд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад 5 хүртэл га атар газрыг Монгол Улсын иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд нь зориулан эзэмшүүлэх асуудлыг тухайн сумын Засаг дарга шийдвэрлэнэ."

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин,  
Р.Бурмаа, Б.Гарамгайбаатар, Ж.Энхбаяр**

**2.Төслийн 24 дүгээр зүйлд "Тариалангийн талбайг мал, амьтны хөлөөс хамгаалах зорилгоор мал төлбөртэй хаших үйл ажиллагааг явуулах зөвшөөрлийг сумын Засаг дарга, иргэн, хуулийн этгээдэд өгч болно" гэсэн хэсэг нэмэх**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл**

**3.Төслийн 18 дугаар зүйлийн "Тариалангийн үйлдвэрлэлийн техникийн худалдааг сургалт, сэлбэгийн хангамж, засвар үйлчилгээний тогтолцоог бүрдүүлсэн, мэргэжил бүхий хүний нөөцтэй, үйлдвэрлэгчийн итгэмжлэлтэй хуулийн этгээд эрхэлнэ." гэсэн 18.2 дахь хэсгийг хасах.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр**

**4.Төслийн 17 дугаар зүйлийн "Тариалангийн бүс нутаг нь хөдөө аж ахуйн чөлөөт бүсэд байж болно." гэсэн 17.3 дахь заалтыг хасах.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун**

**БАЙГАЛЬОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО**